



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 580

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 18,753,179.40 (арван найман сая долоон зуун тавин гурван мянга нэг зуун далан есөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг худалдах хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Т.Төрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайлан дурсгал, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ 
Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА 
Б.ГАВАА

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
280 дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Бартаачийн үе/ | Хүчинчлэгийн үе/ | Үзүүлэлтийн үе/ | Артомашинийн актартай, цагдаагаад хүйслүүдийн доорх опторгийн доорх хэмжээ |
|-----|---|-----------------------------------|-----------------|----------------------|----------------------|--|--|
| 1 | Хьюндай Старекс, УБО 14-18, судлын автобус хөдөлгүүр:128815, арал:104158 | 1998/1998 | 109,100 | 18,753,179.40 | 18,753,179.40 | - | 200,000.00 |
| | | | | 18,753,179.40 | 18,753,179.40 | - | 200,000.00 |
| | | | | | | (арван найман сая долоон зуун тавин гурван мянга нэг зуун далан есөн төгрөг дөчин мөнгө) | (хоёр зуун мянган) |
| | | | | | | Нийт дүн | |